

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ I УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2023.03.24

Улаанбаатар хот

ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтод түвшин, үр дүн (хөрөнгийн эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтод түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО												
3.1.4 Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар төсвийн алдагдлыг бууруулж, сахилга батыг сайжруулна.	126	3.1.4.5. "Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	2021-2024	НҮГ	-	-	Нийслэлийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 3 хувийг эзэлж байна.	Нийслэлийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 4 хувьд хүрсэн байна.	-	-	Хоол зоогийн үйлчилгээний хүнсний бүтээгдэхүүний 90%-ийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хууль дүрмийн хүрээнд худалдан авалтыг хийж байна.	100%
4.1. Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгох.												
	175	4.1.1.2. "Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ.	2021-2024	НҮГ	НЦХМТГ	-	Цахим системийн хөгжүүлэлтийг хийсэн байна.	Хурлын танхимын захиалгыг 100% цахимаар хүлээн авах.	-	-	Хурлын танхимуудын цагийн захиалгыг цахимаар хүлээн авах ажлын хүрээнд www.erp.ulaanbaatar.mn системд нэмэлт цэс оруулан НЦХМТГ болон "Ухаалаг шийдэл ХХК"-тай хамтран ажиллаж хэрэглээндээ бүрэн нэвтрүүлсэн байна.	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
4.1.1.Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг “Нэг цонхны үйлчилгээ”-нд шилжүүлэн, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх бага зардал, цомхон бүтэц бүхий төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн байгуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	176	4.1.1.3."Тоон гарын үсгийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулах.	2021-2024	НЗЗБ-ууд	-	-	ННЗБ-ууд тоон гарын үсгийн хэрэглээнд нэвтрүүлж, тамга тэмдэг, гарын үсэг зурах эрх бүхий 6070 албан хаагчдад тоон гарын үсгийн е-токен төхөөрөмж олгосон.	Тоон гарын үсгийн ашиглалтыг сайжруулж, цахим албан бичгийн харилцааг төгөлдөржүүлнэ.	-	-	Нутгийн захиргааны байгууллагуудын www.erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын систем "Дижитал Монгол" хөтөлбөрийн хүрээнд E-DOC системийн баримт боловсруулалт модулийг ашиглан албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулан тайлант хугацаанд нийт 74 албан бичгийг 100 хувь тоон гарын үсгээр баталгаажуулан хэрэгжүүлж ажилласан байна.	100%
4.1.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлнэ.	179	4.1.2.2."Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний	2021-2024	НЗЗБ-ууд	-	-	Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх стандарт орчинг бүрдүүлсэн эсэх үнэлгээ хийлгэсэн.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх стандарт орчин бүрдэнэ.	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, орчин бүрдүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас "Ээлтэй орчин бүрдүүлэх нь"	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
	182	стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.									сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байр хариуцсан менежерүүд болон угтах үйлчилгээний ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд ННҮГ-ын санаачилгаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 4 ш тэргэнцэр хүлээн авч зарим НҮНТ-д хуваарилан, үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.	100%
		4.1.4.1. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн					Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны хуулийн	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын			Санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тайлант хугацаанд нь гаргаж холбогдох газарт нь хүргүүлж ажиллалаа.	

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
4.1.4. Төрийн байгууллагын ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.	188	дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.	2021-2024	НЗЗБ-ууд	-	-	хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	шилэн дансны хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна	-	-	Шилэн данс, веб хуудаст 19 төрлийн тайлан, мэдээг тухай бүр нь байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан.	100%
4.2.2. Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.		4.2.2.1. "Төрийн албан хаагчдыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч урьдчилан сэргийлэх авлига хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтын тоог бууруулах	2021-2024	НЗЗБ-ууд	-	-	Гэмт хэрэг үйлдсэн 193 төрийн албан хаагч байна. Хээл хахууль авсан 29 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Авлигын 170 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.	Авлига, хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтыг 40%-иар бууруулсан байна.	-	-	Байгууллагын 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, 9 албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны дотор https://meduuleg.iaac.mn/ сайтад байршуулан ажилласан.	100%
4.2.3. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын үеийн материаллаг орчны сайжруулж, орчин шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.		4.2.3.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.	2021-2024	НЗЗБ-ууд	-	-	Ажлын гүйцэтгэл 100% байна.	Ажлын гүйцэтгэл 100% байна	-	-	Тайлант хугацаанд НЗДТГ-ын ХНХТөвөөс зохион байгуулсан ISO 9001:2015 Чанрын удирдлагын тогтолцоо Зөрүүгийн шинжилгээ, Стратеги, төлөвлөгөө	100%

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											боловсруулах арга зүй, Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх сургалтуудад давхардсан тоогоор 66 албан хаагч сургалтад хамрагдсан.	

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН



А.НОМИНЗУЛ

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2023 оны 1-р улирлын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2023 оны 03 дугаар сарын 24-ны өдөр

Улаанбаатар хот

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны 1-р улирлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ үнэлгээг хийж гүйцэтгэв.

2023 оны нэгдүгээр улирлын байдлаар төлөвлөгөөний биелэлтийг холбогдох албан хаагчдаас гаргуулан авч, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-нд заасан аргачлалаар дүгнэлээ.

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг Нийтлэг үйлчилгээний газар хариуцсан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ байхгүй, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хамтран хэрэгжүүлэх 2 бүлгийн 7 заалт (3.1.4.5, 4.1.1.2, 4.1.1.3, 4.1.2.2, 4.1.4.1, 4.2.2.1, 4.2.3.1)-ыг хяналтад авч, холбогдох нэгж, албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллах үүргийг өгсөн.

Дээрх 7 заалтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлыг дүгнэж үзээд дараах үнэлгээг гаргалаа. Хяналтад авсан заалтуудын хүрээнд :

3.1.4.5 НЗДТГ, Хангарди ордны зоогийн газар, Улаанбаатар театр болон Нийслэлийн төр, захиргааны цогцолбор байрны цайны газруудаар дамжуулан нийтийн хоол, хүндэтгэлийн хүлэн авалт, хурлын цайны завсарлага, катеринг үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллаж байна. Хоол зоогийн үйлчилгээний хүнсний бүтээгдэхүүний 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хууль журмын дагуу худалдан авч, хадгалалтын горимыг мөрдөн төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүн, хоол хүнсээр үйлчилж байна.

4.1.1.2 Тус заалтын хүрээнд www.ulaanbaatar.mn системд нэмэлт цэс оруулан хурлын танхимуудыг ашиглах цагийн захиалгыг цахимаар хүлээн авч НЦХМТГ болон Ухаалаг шийдэл ХХК-тай хамтран зохион байгуулж хэрэглээндээ бүрэн нэвтрүүлэн ажиллаж байна.

4.1.1.3 Нутгийн захиргааны байгууллагуудын www.erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын систем “Дижитал Монгол” хөтөлбөрийн хүрээнд E-DOC системийн баримт боловсруулалт модулийг ашиглан албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулан тайлант хугацаанд нийт 74 албан бичгийг 100 хувь тоон гарын үсгээр баталгаажуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

4.1.2.2 Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг ээлтэй, эрүүл, аюулгүй орчинд үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шат дараатай үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар”-т гаргасан хүсэлтийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, орчин нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай туслах хэрэгсэл болох 4 ш тэргэнцрийг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хүлээлгэн өгч мөн Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яамны мэргэжилтэн Б.Болороо “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Тус сургалтад Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын байр хариуцсан менежерүүд, угтах үйлчилгээний ажилтнууд хамрагдав.

4.1.4.1 Санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тайлант хугацаанд нь гаргаж холбогдох газарт нь хүргүүлж ажилласан байна. Шилэн данс веб хуудаст 19 төрлийн тухай бүрт нь байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг бүрэн ханган ажилласан

4.2.2.1 Авилгын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, 9 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 02- дугаар сарын 15-ны дотор <https://meduuleg.iaace.mn/> сайтад заасан хугацаанд мэдүүлсэн. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшилсон болон мэдүүлээгүй албан хаагч байхгүй болно. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

4.2.3.1 Тайлант хугацаанд НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан нийт 3 сургалтад давхардсан тоогоор 66 албан хаагч хамрагдсан байна. Дээрх 7 заалтын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ажлыг хангалттай гүйцэтгэн хэрэгжүүлж ажилласан байна гэж дүгнэлээ.

Хэрэгжилтийн дүн:		
Нийт заалтын тоо		7
Үр дүнтэй	100	6
Тодорхой үр дүнд хүрсэн	70-90	1
Эрчимжүүлэх шаардлагатай	30-70	0
Үр дүнгүй	0-30	0
Үүнээс:	Зохион байгуулалтаас шалтгаалсан	-
	Хөрөнгө дутагдсанаас шалтгаалсан	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	
Биелэлтийн хувь		98,8 %

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газарт хэрэгжүүлж буй “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг улирал бүр дүгнэн, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох нэгж, албан хаагчдад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж ирсэн бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хэрэгжилт 98,8% буюу “Бүрэн хэрэгжсэн” үнэлгээтэй байна гэж үзэж байна.

ДОТООД ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН



Т.АЗЖАРГАЛ